



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/141/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.open.audit.mn

Архангай аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор С.Оргил

Утас: 77665858

Цахим хаяг: Shinjenmagadlahui.ezsh.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025. 02. 25 № 127
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭМАНДАЛ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.БУЯНДЭЛГЭР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд нийт 10 арга хэмжээнд төсвөөс 1,656,257.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэл 80.8 хувь буюу 1,338,856.6 мянган төгрөгийг зарцуулж, 325,765.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 11 үндсэн зорилтын 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 93.2 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

➤ **2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

➤ **2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	346,173,369.29	513,372,073.05
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	194,617,150.87	325,765,354.63
312	Банканд байгаа бэлэн мөнгө	194,617,150.87	325,765,354.63
3121	Төгрөг	194,617,150.87	325,765,354.63
31211	Төрийн сангийн харилцах	194,617,150.87	325,765,354.63
35	БАРАА МАТЕРИАЛ	151,556,218.42	187,606,718.42
351	Түүхий эд материал	360,000.00	360,000.00
3513	Эм боох материал	360,000.00	360,000.00
354	Хангамжийн материал	145,351,218.42	185,686,718.42
3541	Бичиг хэргийн материал	6,122,100.00	7,938,100.00
3542	Аж ахуйн материал	133,182,558.42	171,692,058.42
	Түлш, шахах тослох материал	500,000.00	500,000.00
	Барилга засварын материал	5,546,560.00	5,556,560.00
	Мал амьтан	5,845,000.00	1,560,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,583,101,905.86	1,585,751,858.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,583,101,905.86	1,585,751,858.63
392	Биет хөрөнгө	1,565,635,905.86	1,568,285,858.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,635,143,639.76	1,621,380,349.96
39202	Хуримтлагдсан элэгдэл	(160,407,341.84)	(175,177,572.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,400,548.55	51,574,411.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,548,412.71)	(22,664,915.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,304,148.26	48,870,357.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,319,602.16)	(12,119,528.96)
	Бусад үндсэн хөрөнгө	15,688,126.00	15,688,126.00
	Хуримтлагдсан элэгдэл	(4,935,600.00)	(4,935,600.00)
39217	Ном	340,400.00	340,400.00
393	Биет бус хөрөнгө	17,466,000.00	17,466,000.00
39301	Программ хангамж	300,000.00	300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,166,000.00	17,166,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,929,275,275.15	2,099,123,931.68
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,929,275,275.15	2,099,123,931.68
51	Засгийн газрын хувь оролцоо	1,929,275,275.15	2,099,123,931.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	338,646,155.65	338,646,155.65
51101	Өмч: - төрийн	338,646,155.65	338,646,155.65
512	Хуримтлагдсан үр дүн	1,457,522,061.16	1,627,401,573.69
5121	Өмнөх үеийн үр дүн	1,239,201,241.83	1,457,552,917.16
5122	Тайлант үеийн үр дүн	218,320,819.33	169,848,656.53
	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	133,107,058.34	133,076,202.34
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,929,275,275.15	2,099,123,931.68

➤ 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,125,027,879.00	1,524,836,637.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,316,079.00	45,831,837.13
120	Нийтлэг татварын бус орлого	44,316,079.00	45,831,837.13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,702,146.00	27,758,217.13
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,632,146.00	27,758,217.13
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	20,261,526.00	18,073,620.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	16,352,407.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,080,711,800.00	1,479,004,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,031,541,800.00	1,402,806,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,013,541,800.00	1,402,806,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,170,000.00	76,198,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,170,000.00	76,198,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	905,445,712.87	1,354,987,980.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	905,445,712.87	1,354,987,980.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	888,802,040.42	1,315,808,780.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	550,324,579.85	881,800,568.00
210101	Үндсэн цалин	411,871,440.00	535,272,408.00
210102	Нэмэгдэл	90,284,972.00	301,953,745.00
210104	Урамшуулал	48,168,167.85	44,574,415.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,145,414.18	120,829,578.24
210201	Тэтгэврийн даатгал	46,011,889.46	84,543,574.67
210202	Тэтгэмжийн даатгал	5,413,163.43	11,200,271.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,846,947.77	4,786,150.88
210204	Ажилгүйдлийн даатгал	1,003,766.16	4,059,913.35
210205	Эрүүл мэндийн даатгал	16,869,647.36	16,239,667.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,270,067.55	58,572,763.45
210301	Гэрэл, цахилгаан	14,472,427.55	11,718,706.45
210302	Түлш, халаалт	37,289,000.00	43,530,457.00
210303	Цэвэр, бохир ус	6,508,640.00	3,323,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,553,750.00	22,323,694.05
210401	Бичиг хэрэг	5,314,000.00	4,039,300.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	1,221,000.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	9,018,750.00	18,284,394.05
2105	Нормативт зардал	134,674,700.00	174,422,150.00
210501	Эм	749,400.00	221,800.00
210502	Хоол, хүнс	133,925,300.00	169,915,350.00
210503	Норм хувцас зөөлөн эдлэл	-	4,285,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,880,000.00	2,990,000.00
210604	Урсгал засвар	3,880,000.00	2,990,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,676,300.00	2,281,599.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,676,300.00	2,281,599.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,277,228.84	52,588,427.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,970,150.00	9,239,343.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	123,600.00	167,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43,183,478.84	43,181,884.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,643,672.45	39,179,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,343,600.00	30,179,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,343,600.00	30,179,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	300,072.45	9,000,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	300,072.45	9,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	219,582,166.13	169,848,656.53
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	1,261,346.80	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,261,346.80	-
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУ ҮР ДҮН (VI=IV-V)	(1,261,346.80)	-
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	218,320,819.33	169,848,656.53

➤ 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,080,781,800.00	1,479,004,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	70,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,080,711,800.00	1,479,004,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,013,541,800.00	1,402,806,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,013,541,800.00	1,402,806,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,170,000.00	76,198,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,170,000.00	76,198,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	885,221,194.03	1,347,856,596.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	885,221,194.03	1,347,856,596.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	868,577,521.58	1,308,677,396.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	568,067,614.62	923,023,286.24
210101	Үндсэн цалин	411,342,671.86	597,003,758.61
210102	Нэмэгдэл	125,618,237.78	263,453,936.63
210104	Урамшуулал	31,106,704.98	62,565,591.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,402,379.41	79,606,860.00
210201	Тэтгэврийн даатгал	38,125,202.34	61,746,984.67
210202	Тэтгэмжийн даатгал	5,206,230.00	5,863,044.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,116,610.00	2,782,597.83
210204	Ажилгүйдлийн даатгал	986,590.00	2,527,144.64
210205	Эрүүл мэндийн даатгал	7,967,747.07	6,687,088.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,869,927.55	62,198,000.00
210301	Гэрэл, цахилгаан	15,669,927.55	15,998,000.00
210302	Түлш, халаалт	39,000,000.00	39,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	7,200,000.00	7,200,000.00
2105	Нормативт зардал	133,925,300.00	169,915,350.00
210502	Хоол, хүнс	133,925,300.00	169,915,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,676,300.00	3,963,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,676,300.00	3,963,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,636,000.00	64,970,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,607,200.00	52,898,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,028,800.00	12,071,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,643,672.45	39,179,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,343,600.00	30,179,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,343,600.00	30,179,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	300,072.45	9,000,000
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	300,072.45	9,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	195,560,605.97	131,148,203.76
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,000,000.00	-
	Дотоод эх үүсвэрээр	3,000,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,000,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,000,000.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	192,560,605.97	131,148,203.76
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,056,544.90	194,617,150.87
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	194,617,150.87	325,765,354.63

➤ **2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	338,646,155.65	133,127,358.34	1,239,180,941.83	1,710,954,455.82
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			20,300.00	20,300.00
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	338,646,155.65	133,127,358.34	1,239,180,941.83	1,710,954,455.82
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(20,300.00)		(20,300.00)
16	Тайлант үеийн үр дүн			218,320,819.33	218,320,819.33
9	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	338,646,155.65	133,107,058.34	1,457,522,061.16	1,929,275,275.15
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			30,856.00	30,856.00
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	338,646,155.65	133,107,058.34	1,457,552,917.16	1,929,306,131.15
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(30,856.00)		(30,856.00)
16	Тайлант үеийн үр дүн	-	-	169,848,656.53	169,848,656.53
17	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	338,646,155.65	133,076,202.34	1,627,401,573.69	2,099,123,931.68

➤ **2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,656,257,700.00	1,338,856,596.24	317,401,103.76	80.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,656,257,700.00	1,338,856,596.24	317,401,103.76	80.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,626,078,500.00	1,308,677,396.24	317,401,103.76	80.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,146,152,000.00	923,023,286.24	223,128,713.76	80.5
210101	Үндсэн цалин	781,155,800	597,003,758.61	184,152,041.39	76.4
210102	Нэмэгдэл	335,081,900.00	263,453,936.63	71,627,963.37	78.6
210104	Урамшуулал	29,914,300.00	62,565,591.00	-32,651,291.00	209.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,209,700.00	79,606,860.00	51,602,840.00	60.7
210201	Тэтгэврийн даатгал	89,225,700.00	61,746,984.67	27,478,715.33	69.2
210202	Тэтгэмжийн даатгал	10,493,800.00	5,863,044.58	4,630,755.42	55.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,248,200.00	2,782,597.86	2,465,602.17	53.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,248,200.00	2,527,144.64	2,721,055.36	48.2
210205	Эрүүл мэндийн даатгал	20,993,800.00	6,687,088.28	14,306,711.72	31.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,198,000.00	62,198,000.00	9,000,000.00	87.4
210301	Гэрэл, цахилгаан	24,998,000.00	15,998,000.00	9,000,000.00	64.0
210302	Түлш, халаалт	39,348,000.00	39,000,000.00	348,000.00	99.1
210303	Цэвэр, бохир ус	6,852,000.00	7,200,000.00	-348,000.00	105.1

2105	Нормативт зардал	199,074,500.00	169,915,350.00	29,159,150.00	85.4
210502	Хоол, хүнс	199,074,500.00	169,915,350.00	29,159,150.00	85.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00		100
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00		100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,963,700.00	3,963,700.00		100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,963,700.00	3,963,700.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,480,600.00	64,970,200.00	4,510,400.00	93.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,408,900.00	52,898,500.00	4,510,400.00	92.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,071,700	12,071,700		100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,179,200.00	30,179,200.00		100
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,179,200.00	30,179,200.00		100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,179,200.00	30,179,200.00		100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,656,257,700.00	1,479,004,800.00	177,252,900.00	89.3
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,402,806,800.00	1,402,806,800.00		100
131001	Улсын төсвөөс санхүүжих	1402,806,800.00	1,402,806,800.00		100
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	76,198,000.00	76,198,000.00		100
132001	Орон нутгийн төсвөөс	76,198,000.00	76,198,000.00		100
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	177,252,900.00		177,252,900.00	
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	177,252,900.00		177,252,900.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		194,617,150.87	-	194,617,150.87
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		194,617,150.87	-	325,765,354.63
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100
610001	Төсвийн байгууллага	1	1		100
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	37	37		100
6	Удирдах ажилтан	1	1		100
7	Гүйцэтгэх ажилтан	21	21		100
8	Үйлчлэх ажилтан	15	15		100

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **4,077.0** мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил таслан зогсоож, арилгуулах 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 4,077.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 18,632.9 мянган төгрөгөөс бага, шинж чанарын хувьд материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Тайлант онд 1 сард 120 кг буюу 1,080.0 мянган төгрөгийн, 2 сард 112 кг буюу 1,008.0 мянган төгрөг нийт 2,088.0 мянган төгрөгийн хүүхдийн хоолны махны нормыг илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2024 оны Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 254 дүгээр тогтоолыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1 Бараа материалын дансны аж ахуйн материалын дансанд 3 нэр төрлийн 1,989.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг буруу бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “Үнэн зөв байх”, 5.1.5-д “хэмжигдэхүйц бай”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоод хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, 73 дугаар зүйлийн 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж, дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын дансанд бүртгэлтэй байгаа үндсэн хөрөнгийг залруулж бүртгэн, тайлагнах арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон ахуйн хэрэгслийн орлого, зардлын бүртгэл тайлантай холбоотой.

Илрүүлэлт:

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан жагсаалтын дагуу эцэг, эх, асран хамгаалагчдаас хүлээн авсныг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг хүлээн авсан үед бараа материалын зохих дансанд орлогоор, сургалтын үйл ажиллагаанд тавьж олгосон тухай бүр зардлаар бүртгэж бараа материалын тайлан бэлтгэж үр дүнг санхүүгийн тайланд тусгаж, мэдээлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалын дансанд хөрөнгийг буруу бүртгэсэн	1	1,989.0	-	-	1	1,989.0	-	-				
Хүүхдийн хичээлийн хэрэглэл сургалтын хэрэглэгдэхү үнийг бүртгэл тайланд тусгаагүй.	1	-	-	-	-	-	1	-				
Хүүхдийн хоолны махны нормыг илүү зарцуулсан	1	2,088.0	1	2,088.0								
Нийт дүн	3	4,077.0	1	2,088.0	1	1,989.0	1	-				